



ORI
STUDIOS

www.ori.mn



ОРИ СТУДИОС ХХК

“Ори Студиос” ХХК нь Монгол HD ТВ-ийн санаачилгаар 2020 онд үүсгэн байгуулагдсан. Бид ОУСтандартад нийцсэн техник тоног төхөөрөмжийн тусламжтайгаар мэргэшсэн багтай хамтран дотоод, гадаадын кино, контентуудыг үндсэн форматын дагуу дуу дүрсний өндөр чанартайгаар бүтээж, үзэгчдэд хүргэх түүнчлэн Монгол соёл, түүх, зан заншлаа дэлхийд сурталчлан таниулах уран бүтээл туурвиж, үндэсний дархлааг тогтоох зорилготой.

ХУРААНГУЙ

Ори Студиос төсөл нь эх хэл, түүх, өв соёлоо дээдэлсэн эх оронч үзэлтэй Монгол хүнийг хөгжүүлэх, нийгмийг соён гэгээрүүлэх түүнчлэн үндэсний хэв шинж, үзэл бодол, гүн ухаан, гоо зүй, соёл, амьдралын хэв маягийг харуулсан ОУСтандартад нийцсэн бүтээл туурвих зорилготой кино болон контент үйлдвэрлэгчдийн нэгдсэн медиа хабыг байгуулж, ирээдүй хойч үедээ оюуны өвийг үлдээнэ.

- Монголын контент үйлдвэрлэлийн оролцогчдыг чадавхжуулж, медиа салбарын нэгдсэн төв байгуулах;
- Гайхалтай бүтээлийн санал санаачилгыг олон түмний хүртээл болгох хүртэл бүх үйл ажиллагааг нэг дор цогцлоох;
- ОУ кино багтай хамтран ажиллаж МУ-ын бүтээл үйлдвэрлэлийн экспортыг нэмэгдүүлэх, эх орноо сурталчлан таниулах, импортыг орлох бүтээлч үйлдвэрлэлийн салбарыг хөгжүүлэх замаар ДНБ-д эзлэх хувь хэмжээг нэмэгдүүлэх;
- Дэлхийн стандартад нийцсэн барилга байгууламж, мэргэжилтэн, тоног төхөөрөмжийн тусламжтайгаар чанартай бүтээл туурвиж ОУЗЗ дахь энтертаймент салбарт оюуны бүтээлээр нэвтрэн орох.

ЭРХЭМ ЗОРИЛГО

ОУСтандартад нийцсэн техник тоног төхөөрөмжийн тусламжтайгаар мэргэшсэн багтай хамтран дотоод, гадаадын кино, контентуудыг үндсэн форматын дагуу дуу дүрсний өндөр чанартайгаар бүтээж, үзэгчдэд хүргэх түүнчлэн Монгол соёл, түүх, зан заншлаа дэлхийд сурталчлан таниулах уран бүтээл түүрвиж, үндэсний дархлааг тогтооно.

АЛСЫН ХАРАА

Чанартай уран бүтээлээс соён гэгээрэл, мэдлэг, соёлын дархлаа, үнэт зүйлсийг бий болгон бүтээлч соёлыг цогцлооно.

ҮНЭТ ЗҮЙЛС

- ✓ Чанартай бүтээл;
- ✓ Чин сэтгэл;
- ✓ Ёс зүй;
- ✓ Хамтын зүтгэл;
- ✓ Үзэгч;
- ✓ Оюуны өмч;
- ✓ Нийгмийн хариуцлага;
- ✓ Төгөлдөршил.

ТӨСЛИЙН САНААЧЛАГЧ & УДИРДЛАГА



Төслийн санаачлагч Г.Бат-Эрдэнэ нь 2000 онд Өсвөрийн Зохион Бүтээгчдийн Дунд Сургууль, 2004 онд Зүүн Английн Их Сургууль - Улс төр, нийгэм судлалаар, 2009 онд Монголын Чөлөөт Бөхийн Холбооны Ерөнхий нарийн бичгийн даргаар, 2010 онд Номсис ХХК - Үүсгэн байгуулагч, Ерөнхий захирал, 2012 онд Монгол телевиз - Стратеги бодлого төлөвлөлт хариуцсан дэд захирал, 2018 оноос Монголын Телевизүүдийн Холбооны УЗДаргаар, 2021 оноос Монгол телевиз - Гүйцэтгэх захирлаар томилогдон ажиллаж байна. Мөн Киноны тухай хуулийг боловсруулах ажлын хэсэгт орж, хуулийн төслийг өргөн барихаар ажиллаж байгаа.

Төслийн Санаачлагч Ч.Номин нь Их Британийн Ийст Англиа Их Сургуулийг эдийн засгийн чиглэлээр төгссөн. 2006 - 2007 онд Гацуурт Группийн Гадаад Харилцааны Захирал, 2007 оноос Тэрэлж зочид буудлын Ерөнхий Менежер, 2011 оны 2 сараас эхлэн Монгол HD телевизийн захирлаар ажиллаж, телевизийн контентын бодлого, оюуны өмчийн талаарх эрчимтэй өөрчлөлтүүдийг өөрийн телевиздээ хийн, энэ үйл явцдаа бусдыгаа ч уриалан, манлайлж байгаа. 2013 онд телевизийн салбар дахь Дэлхийн нөлөө бүхий 25 эмэгтэйн нэгээр шалгарсан. 2021 оны 1 сарын 29-нд **Соёлын Сайдаар** ажиллахаар томилогдсон.




Төслийн удирдагч Д.Бат-Оюун нь 2012 онд Английн Уэлсийн Их Сургуулийг Банк, санхүүгийн чиглэлээр МВА зэрэгтэйгээр суралцаж төгссөн. 2007 оноос эхлэн Монголын тэргүүлэгч арилжааны банк болох ХХБ болон гадаадын хөрөнгө оруулалттай олон улсын менежментийн багт Санхүүгийн менежерээр ажиллаж байсан туршлагатай. 2020 онд Монгол ТВ-ээс зохион байгуулсан Аппрентис Монгол шоунд амжилттай оролцсон мөн ОРИ СТУДИОС төслийн удирдагчаар ажиллаж эхэлсэн.

ТӨЛӨВЛӨЖ БУЙ БАРИЛГА БАЙГУУЛАМЖ



ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨЛТ



ХЭРЭГЖИХ ҮНДЭСЛЭЛ

Дэлхийг хамарсан бүтээлч үйлдвэрлэлийн хурдацтай хөгжил, бүтээгдэхүүн ба бүтээлч үйлчилгээний хэрэглэгч болсон монголчуудын хувьд зөвхөн хэрэглэгч, худалдан авагч байх нь гадны соёлын хэрэглээнд автах, өөрсдийн хэл, соёл, өв уламжлалаас холдон хөндийрөх эрсдэл үүсч байна.

КОНТЕНТ ТӨЛӨВЛӨЛТ

Бид контент төлөвлөлтийн хувьд 10-20 жилийн туршлагатай, дотоодын болон олон улсын мэргэжилтнүүдээс бүрдсэн баг үр ашиг бүхий боломжит төслүүдийн стратегийн төлөвлөлтийг хийж, хэрхэн амжилттай хэрэгжүүлэх арга замыг тодорхойлох юм.

КОНТЕНТ ҮЙЛДВЭРЛЭЛ

Бид бүхэн өнгөрсөн хугацаанд дэлхийн томоохон шоу нэвтрүүлгүүдийг салбар компаниудынхаа хамтаар олон улсын стандартын дагуу амжилттай бүтээж нэвтрүүлсэн. Цаашид Ori Studios буюу контент үйлдвэрлэлийн нэгдсэн үйлчилгээг үзүүлэх цогцолбор байгуулж, олон улсын кино багууд, медиа компаниудтай хамтран ажиллах, өөрсдийн оригинал бүтээлүүдийг бий болгохоор зорьж байна.

КОНТЕНТ БОРЛУУЛАЛТ

Өөрсдийн үйлдвэрлэсэн бүтээлүүдээ дотооддоо төдийгүй олон улсын дамжуулалтын сувгуудад борлуулж, түгээн дэлгэрүүлэх зорилттой ажиллаж байна. Үүний хүрээнд шинээр гарч ирж буй бүтээлийг ОРИ апп ОТТ, өргөн дэлгэц, IPTV, кино театрууд руу борлуулна.

КОНТЕНТ ТҮГЭЭЛТ

Бид контент түгээлтийн шинэ хандлага болох ОТТ /over the top/ технологид суурилсан стримингийн Ori апп, мөн өргөн дэлгэцээр өөрсдийн бүтээсэн контентуудаа цацах, улмаар олон улсын стриминг буюу дахин дамжуулалтын сувгуудад контентуудаа борлуулах зорилтыг тавин ажиллаж байна.

ҮЙЛ АЖИЛЛАГАА

Медиа хаб болж кино контент үйлдвэрлэгчдийн нэгдсэн платформ байгуулах тул бүтээлийн санаа гаргах процессоос эцсийн үзэгчдэд хүргэх шат дамжлага хүртэл бүх шатны шилдэг мэргэжилтэн, тэргүүлэгч байгууллагууд, тоног төхөөрөмж, дэд бүтэц, үйлдвэрлэлийн орчныг кластер байдлаар хөгжүүлнэ.

БҮТЭЭЛЧ ҮЙЛДВЭРЛЭЛ



Кино, контент



ОУ хамтын ажиллагаа



Креатив сервис



Талант хаб



CGI, VFX, SFX



Концерт



Спорт



Хурим



Драм тоглолт



Конференс

ТҮРЭЭСИЙН ҮЙЛЧИЛГЭЭ



Төхөөрөмж



Оффис



Сервер, DAM



Экспертүүд



Hi-Tech



Медиа тусламж



Түншлэл



Медиа инкубатор



Соён гэгээрүүлэх



Сурталчилгаа

АРГА ХЭМЖЭЭ

БУСАД

ТУЛГАРЧ БУЙ АСУУДЛУУД

ШИЙДЭЛ БА ХИЙХ АЖИЛ

Монгол улсад Төрийн кино бодлого байхгүй Цаашид Монгол үндэстэн соёл, үүх түүхээ алдаж уусч алга болох эрсдэлтэй 1990 оноос өмнө төрөөс санхүүжилт авдаг байсны ачаар сайн чанарын алтан үеийн бүтээлүүд туурвигдсан. Түүнээс хойш 30 жил кино урлагт ямар ч үлс төрийн дэмжлэггүй хөгжиж байна.



Контент болон уран бүтээлийн төлөвлөгөө 5 жилээр мэргэжлийн багтай хамтран боловсруулна Нийт бүтээл үйлдвэрлэлийн харьцааг 1 25:20:20:35 байдлаар төлөвлөж ажиллана. Уран бүтээл туурвилд шаардлагатай бүх нөөцийг нэг дор цогцлооно. /дэд бүтэц, санхүү, хүний нөөц г.м/

Зөөлөн хүчний бодлого гэж нэрлэглэх энтертайнмент болон кино, контентоор дамжуулан соёлын дархлааг сулруулж, оюун санааг эргүүлэх, өөрийн ашиг сонирхлыг далдуур хүлээн зөвшөөрүүлэх том гүрний бодлого шингэсэн олон бүтээлүүд манай орны ТВ болон сошиал сүвгаар шууд цацагдаж байгаа.



Үндэсний соёлын дархлааг дэмжих зорилгоор жил бүр контентын агуулгад хүүхэд, залуучуудад зориулсан түүхэн болон орчин үеийн чиг хандлагад нийцсэн бүтээлийн эзлэх хувийг 20%-иас багагүй байлгахаар төлөвлөж ажиллана.

Монголын кино урлагийн эдийн засгийн эрэлт жилд 10 тэрбум буюу 3,5 сая доллар байна. Жил бүр өсч байгаа ч ОУЗЗ-тэй харьцуулахад маш бага үзүүлэлт юм



Ирэх 10 жилийн хугацаанд бүтээлч салбарын ДНБ-д эзлэх хувийг 10%2-д хүргэх зорилготойгоор төслийн хэрэгжилт болон салбарын хамт олноо манлайлан ажиллана.

Кино контент бүтээхэд студи чухал боловч манайд томоохон чанартай бүтээл туурвих хүчин чадал сайтай кино үйлдвэр одоогоор байхгүй. Монгол кино үйлдвэрийн барилга элэгдэлд орсон тул дахин ашиглах боломжгүй болсон. Хурдацтай хөгжиж буй техник технологийн шинэчлэлээс шалтгаалан байнга тоног төхөөрөмжөө сайжруулах шаардлага тулгарсан



Ори Студиос нь монголын хамгийн анхны 2000 студийн хэмжээгээр байгуулагдана ОУКино контент бэлтгэх шалгуурт нийцүүлэн хүчин чадлаа төслийн эхний 3 жилд багтаан 5 дахин томруулах төлөвлөгөөтэй ажиллана. ОУ франчайс форматын дагуу контент үйлдвэрлэлийг тасралтгүй чанартай бүтээх бүх орчин, ХН, техник тоног төхөөрөмжийг бэлэн байдлыг зэрэгцүүлэн хангана.

Монгол улсын хууль тогтоомжид кино салбартай холбоотой бэлэн мөнгөний буцаан олголт, татварын хөнгөлөлт байхгүй. Буцаан олголттой газар л ОУКино баг зураг авалтаа хийдэг. Оюуны өмчийн хамгаалалт, оюуны өмчийн зөрчил дутагдалтай тал ихтэй байна.



Засгийн газрын түсгэй сангийн тухай хуулийн хүрээнд Кино урлагийг дэмжих сан байгуулсан. Тус санд 10 тэрбум төгрөг төсөвлөсөн байна. ОУ багийн манай улсад зарцуулсан мөнгөний тодорхой хувийг эргүүлэн олгодог болгохоор хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт оролцож байгаа.

1998-2008 оны хооронд кино урлагийн салбар уналтад орсон шалтгаан нь мэргэжлийн бус хүмүүс кино хийсэнтэй холбоотой. Кино урлаг өндөр хөгжсөн улс орнуудад 125 мэргэжил байдаг бол манай улсад ердөө найруулагч, жүжигчин, зураглаач, зураач зэрэг 6 мэргэжлийн уран бүтээлч бэлтгэдэг. Жилд 100 гаруй мэргэжилтэн л шинээр бэлтгэгддэг.




Манай баг ОУСтандарт шаардлага, форматын дагуу шинэ шоу болон кино контент бэлтгэх явцдаа уран бүтээлчдээ чадавхжуулах хөтөлбөрийг хавсарч хийнэ. ОУ кино баг болон медиа салбарын хөгжлөөр дэлхийд тэргүүлж байгаа БНСУ болон Хятадын мэргэжилтнүүдээс зөвлөх үйлчилгээгээр хамтран ажиллана

Өнгөрсөн 100 жилд төрийн дэмжлэгээр бүтээсэн том хэмжээний хэдхэн киноны нэг нь "Мандухай сэцэн хатан" ба Монголд үйл ажиллагаа явуулж байгаа 900 гаруй кино студиас ийм хэмжээний уран бүтээл туурвиагүй байна.




Ори студиос нь бүх шатны шилдэг мэргэжилтэн, тэргүүлэгч байгууллагууд, тоног төхөөрөмж, дэд бүтэц, үйлдвэрлэлийн орчныг кластер байдлаар хөгжүүлнэ. ОУКино болон контент үйлдвэрлэлийн стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх арга хэмжээг ЕСБХБанкны мэргэжлийн зөвлөхүүдтэй хамтран хэрэгжүүлнэ.


БҮТЭЭЛЧ САЛБАРЫН ЭКОСИСТЕМ



МЕДИА ТӨВИЙН ЭКОСИСТЕМ



УРАН БҮТЭЭЛИЙН ЭКОСИСТЕМ



ХОЛБОО БАРИХ:

✉ info@oristudios.mn

☎ +976-99042526

📍 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө, Монгол ТВ Тауэр, 10 давхар, 1007 тоот

